



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 05 сарын 27 өдөр

Дугаар А/125

Бор-Өндөр сум

**Замын хөдөлгөөнийг хэсэгчлэн түр
хугацаагаар хязгаарлах тухай**


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 59 дүгээр зүйлийн 59.1.23 дэх хэсэг, Зам хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хүүхдийн баярыг тохиолдуулан 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдөр баталсан маршрутын дагуу 09⁰⁰-20⁰⁰ цагийн хооронд тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг түр хугацаагаар хязгаарласугай.

2.Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлах замын маршрутыг хавсралтаар баталсугай.

3.Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бор-Өндөр сумын Сум дундын Цагдаагийн хэлтсийн дарга, цагдаагийн дэд хурандаа (Т.Энхбаяр)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.АДЪЯАБИЛЭГТ